



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/69

Ховд

Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн наймдугаар хуралдааны 8/04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар тогтоолын 2, 3 дугаар хавсралтын Орон нутгийн хөрөнгө оруулалтын 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, арга хэмжээний жагсаалтын 2.8 дахь заалтын "Бохирын машин" худалдан авах 50,0 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, арга хэмжээний жагсаалтын 2.7 дахь заалтын "Гэрэлтүүлэг" 35,0 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг Булган сумын Засаг дарга /Б.Амгаланбадрах/-д шилжүүлсүгэй.

2. Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг үндэслэлтэй боловсруулж 2 дугаар сарын 20-ны дотор Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээр хянуулан баталгаажуулсны үндсэн дээр, худалдан авах ажиллагааг 3 дугаар сарын 25-ны дотор холбогдох хууль, журмын дагуу ил тод, нээлттэй, шуурхай зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулж, ашиглалтанд хүлээн авах зэрэг хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, үр дүнг 8 дугаар сарын 20-ны дотор тайлагнахыг сумын Засаг дарга /Б.Амгаланбадрах/-д даалгасугай.


Зах А/69 Чх
02.00337

3. Эрх шилжүүлж буй хөрөнгө оруулалтын захиалагчийн хяналтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /С.Гантөмөр/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /П.Эрдэнэчулуун/ нарт хариуцуулсугай.

4. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж, өмч бүртгэлд тусгахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/, холбогдох бичиг баримтын бүрдлийг хянаж санхүүжүүлж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /С.Гантөмөр/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

